

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн төвийн Захирлын 2022 оны 07 сарын 29-ны/ний өдрийн АД/С тоот тушаалын д/р хөвсралт

БАТЛАВ

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН УЙЛДВЭРИЙН
СУДАЛГАА ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ

/Б.БАТХҮҮ/

ИНКУБАТОРЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

2022 оны __ сарын __ -ны өдөр
Улаанбаатар хот № __

Нэг талаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төв /цаашид “Судалгаа хөгжлийн төв” гэх/, түүний төлөөлж И nnovаци, нэвтрүүлэлтийн хэлтсийн дарга Д.Даваадорж, нөгөө талаас “_____” ХХК/цаашид “Бойжигч” гэх/, түүнийг төлөөлж захирап _____ нарыг Иргэний хууль, “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн инкубаторын үйл ажиллагааны журам” /цаашид “журам” гэх-/ыг тус тус үндэслэн дор дурдсан нөхцөлийг харилцан тохиролцож “Инкубаторын үйлчилгээ үзүүлэх гэрээ” /цаашид “гэрээ” гэх-/г байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.3. Энэхүү гэрээний зорилго нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарг окоуны өмчид тулгуурласан шинэ дэвшилтэг технологи, мэдлэгт сууринсан бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг нэвтрүүлэх, импортыг орлох, экспортын чиг баримжаатай гарааны компанийг хөгжүүлэх иргэн, аж ахуйн нэгжийг Судалгаа хөгжлийн төвийн инкубаторт элсүүлэх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, төгсгөхтэй холбоотой харилцааг Монгол Улсын холбогдох кууль, тогтоомжид нийцүүлэн зохицуулахад оршино.

ХОЁР.ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1. Гэрээний эхлэх хугацаа: 20.. оны __ сарын __ -ны өдөр.
- 2.2. Гэрээний дуусах хугацаа: 20.. оны __ сарын __ -ны өдөр.
- 2.3. Талууд гэрээнд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

ГУРАВ. “СУДАЛГАА ХӨГЖЛИЙН ТӨВ”-ИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Бойжигчийн үйлдвэрлэл үйл ажиллагааны ур дунд бий болсон биет бус бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг харилцан тохиоролцсоны үндсэн дээр бойжигч талын нэрийг мэдээлэл сурталчилгаанд ашиглах, цахим хуудсандаа байршуулах;

3.2. Журамд заасны дагуу бойжигчийн батлагдсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах ба хагас жил тутамд, тайланг хулзэн авах, үнэлгээ дүгнэлт өгөх;

3.3. Инкубаторт бойжууллахад чиглэсэн менежментийн ур ашигтай, оновчтой шийдлийг талууд гаргаж, саналыг харилцан хэлэлцэж зөвшилцөх;

3.4. Бойжигчийн үйл ажиллагааг өргөжүүлэх үүднээс сургалт, зөвлөх үйлчилгээ үзүүлэх;

3.5. Гадаад, дотоодын үзэсгэлэн худалдаанд оролцох арга зам болон зохицуулалтын дэмжлэг үзүүлэх.

3.6. Загвар аж ахуйд талбайн тариалалтын туршилт, судалгааны ажлын арга зүйгээр хангах;

3.7. Судалгаа хөгжлийн төвийн байранд байрлах бойжигч нь Төрийн өмчийн бодлого зохицууллах газраас гаргасан тарифын дагуу түрээсийн гэрээ байгуулж ажилана;

ДӨРӨВ. “БОЙЖИГЧ”-ИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Зөвхөн зөвшөөрсөн үйл ажиллагааг явуулах ба зөрчсөн бол гэрээг цуцална;

4.2 Бойжигч нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон Судалгаа хөгжлийн төвтэй “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ” байгуулан гэрээний заалтыг дагаж мөрдөх үүрэгтэй;

4.3 Үйл ажиллагааны үр дунд бий болсон биет бус бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнд технологийн хөгжүүлэлт хийгдсэн бол харилцан тохиоролцсоны үндсэн дээр хаяг шошгонд Судалгаа хөгжлийн төвийн логоог байршуулах, сурталчилгаанд ашиглах, цахим хуудсандaa байршуулах;

4.4 Бойжигч нь ажлын байрны орон тоо, үйл ажиллагааны үр дунгээс хамааран байр, эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалтыг сайжруулах, цар хурээг нэмэгдүүлэх талаар Судалгаа хөгжлийн төвд санал, хүсэлт тавих;

4.5 Бойжигч нь өөрийн эрхэлж буй үйл ажиллагааны хүрээнд уялдаатайгаар хурал, уулзалтын өрөөг ашиглах;

4.6 Сургалтад оролцох, хамтран зохион байгуулах;

4.7 Судалгаа хөгжлийн төвийн барилга, тоног төхөөрөмж, эд хөрөнгөнд гэмтэл, эвдрэл гарвал нэн даруй Судалгаа хөгжлийн төвд мэдэгдэх;

4.8 Судалгаа хөгжлийн төвд мэдэгдэхгүйгээр барилгын хийц, эд хөрөнгөнд өөрчлөлт хийхийг хориглоно.

4.9 Инкубаторт бойжигч нь тухай оны 06 дугаар сарын 25, 12 дугаар сарын 1-нд хагас болон жилийн үйл ажиллагааны тайлан, бусад шаардлагатай мэдээллийг Судалгаа хөгжлийн төвд ирүүлэн дүгнэлт гаргуулах.

4.10 Бойжигч нь жендерийн тэгш байдал, бэлгийн дарамт, согтууруулах ундаа, мансууруулах бодис болон хуулиар хориглосон бусад үйл ажиллагаа, ёс бус үйлдэл гаргахгүй байх ширэг хүлээнэ.

4.11 Холбогдох хууль, дүрэм журам болон энэхүү гэрээнд заасан үргээ зохих ёсօор биелүүлэхийг харилцан шаардах;

4.12 Гэрээний хугацаандаа хамт бойжигч буй бойжигч наарт өөрсдийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд туршлага солилцох арга хэмжээг санаачлан зохион байгуулах;

4.13 Судалгаа хөгжлийн төвийн шаардсан стандартын дагуу хаягилт хийх;

ТАВ. БОЙЖИГЧИД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

5.1 Байршиж буй бойжигчийн ажлын байрны түрээсийн төлбөрийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай” 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 49 тоот тогтоопоор зохицуулна.

5.1.1 Судалгаа хөгжлийн төвийн байранд байршигүй гадуур байршиих тохиолдолд дээрх заалт хамаарахгүй зөвхөн энэхүү гэрээг баримтлан ажиллана.

5.2 Инкубаторт бойжигчийн үйлчилгээг тапууд тухай бүрд харилцан тохиролцож хэрэгжүүлэх.

5.3 Судалгаа хөгжлийн төвийн зүгээс бойжигчид хавсралтад заасан үйлчилгээ үзүүлнэ.

ЗУРГАА. ГЭРЭЭГ СҮНГАХ, ЦУЦЛАХ

6.1 Гэрээг холбогдох журам, энэхүү гэрээний заалтыг үндэслэн сунгах болон цуцална.

6.2 Гэрээг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн инкубаторын үйл ажиллагааны журамд заасны дагуу цуцлахаас гадна Судалгаа хөгжлийн төвийн зүгээс дараах тохиолдолд гэрээг цуцална. Үүнд:

6.2.1 Үндсэн чиглэлийн үйл ажиллагаанаас өөр үйл ажиллагаа явуулах, хуулиар хориглосон бусад үйл ажиллагаа явуулсан нь тогтоогдсон бол;

6.2.2 Гэрээгээр хүлээсэн ширэг зөрчсөн, үл биелүүлсэн;

6.2.3 Байрлаж буй байр талбай, эд хөрөнгийг зориулалтын бусаар ашигласан;

6.3 Инкубаторт бойжигч нь байрших хугацаандаа компани нь татан буугдсан, дамжуурсан нөхцөлд “Инкубаторын үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г дуусгавар болсонд тооцно.

ДОЛОО. ГЭРЭЭГ ДҮГНЭХ

7.1 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн инкубаторын үйл ажиллагааны журамд заасны дагуу хийгдэх үнэлгээг дараах үзүүлэлтүүдийг харгалзан Судалгаа хөгжлийн төвийн “Инкубаторт сонгон шалгаруулах ажлын хэсэг”-ийн гишүүд 1-10 хүртэлх оноогоор үнэлж, ажлын хэсгийн нарийн бичиг дарга нь ажлын хэсгийн гишүүдийн саналыг Нэгтгэн дүнг гарган ажилана. Үнд:

7.1.1 Бизнес төлөвлөгөөний биелэлт;

7.1.2 Судалгаа хөгжлийн төвийн зүгээс үзүүлсэн сургалтын болон бусад үйлчилгээнд хамрагдсан байдал;

7.1.3 Гэрээний үүрэг хариуцлагын биелэлт болон хамтын ажиллагаа;

7.1.4 Бойжих хугацаанд хүрсэн үр дүн;

7.1.5 Дотоод, гадаадын зах зээлд бараа, бүтээгдэхүүний борлуулалтын байдал;

7.1.6 Эдийн засгийн үр ашиг нэмэгдсэн эсэх;

7.1.7 Бойжигчийн зүгээс санаачлан зохион байгуулсан арга хэмжээ, үйл ажиллагааны үр дүн;

7.1.8 Санхүүгийн тогтвортой байдал, сахилга бат

НАЙМ. ГЭРЭЭНИЙ НУУЦЛАЛ, ХАРИУЦЛАГА

8.1 Бойжигчийн үйл ажиллагаанд өгсөн ажлын хэсгийн үнэлгээ, хурлын тайлан, Тэмдэглэлийг нууцад хамааруулна.

8.2 Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үргээ чанд сахин биелүүлэх үрэгтэй.

8.3 Хамтран ажиллах хугацаандаа ажил үргийн шаардлагаар олж мэдсэн, зэмшиж, ашиглаж байсан баримт бичиг, мэдээ материал, талуудын бизнесийн ашиг сонирхолд шууд болон шууд бус хамааралтай аливаа мэдээллийг нөгөө талын зөвшөөрөлгүйээр бусдад аман болон бичгээр, өөр бусдад хэлбэрээр задруулахгүй байх, бусдад этгээдийн эрх ашигийн төлөө ашиглахгүй байх үргийг талууд хүлээнэ.

8.4 Гэрээнд зааснаас бусад асуудлаар талууд өөр хоорондын ашиг сонирхлыг хөндсөн хөндлөнгийн аливаа үйлдэл хийхгүй байх.

8.5 Талуудын хариуцлагагүй үйлдлийн үр дунд бий болсон алдагдал хохирол, бусад этгээдийн өмнө үүссэн хариуцлагыг буруутай тал хариуцна.

8.6 Нууцыг хоёр тал зөвшөөрсөн эсхүл хууль хүчиний байгууллагын зүй ёсны шаардлагаар ил болгоно.

ЁС. СУДАЛГАА ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЭД ХӨРӨНГӨ, ТҮҮНИЙ АШИГЛАЛТ

9.1 Инкубаторт бойжигчийг байршуулахаа Судалгаа хөгжлийн төвийн “Өмч хамгаалах байнгын зөвлөл” нь эд хөрөнгийн эвдрэл, элэгдэл, чанарыг нэг бүрчлэн

дурдсан бүртгэлийн маягтын дагуу акт үйлдэн, гарын угсээр баталгаажуулж хариуцуулж өгнө.

9.2 Бойжигч нь ажлын байрандаа барилгын хийцлэл хана, тааз болон бусад хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Судалгаа хөгжлийн төвөөс зөвшөөрөл авна.

9.3 Бойжигч нь гэрээний хугацаанд Судалгаа хөгжлийн төвийн эд хөрөнгийг гэрээнд заасан нөхцөл, зориулалтаар нь ашиглаж, түүний бүрэн буйдлыг хангах ба буруу эзэмшиж, ашигласнаас уссэн засвар, эвдрэл, гэмтлийн зардлыг өөрийн хөрөнгөөр хохирлыг бүрэн барагдуулна.

9.4 Эд хөрөнгийн /хана, тааз, тавилга, хаалга/ эвдрэл, гэмтлийг буруутай тал ажлын 5 өдрийн дотор нөхөн төлөх хариуцлага хүлээнэ.

9.5 Гэрээний хугацаа дуусгавар болсон эсхүл гэрээг цуцалсан тохиолдолд Судалгаа хөгжлийн төвийн байр, эд хөрөнгийг бүртгэлийн маягтын дагуу "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-д хүлээлгэн өгнө.

АРАВ. БУСАД ЗААЛТ

10.1 Бойжигч нь инкубаторт байрших хугацаанд үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд Судалгаа хөгжлийн төвтэй харицан тохиоролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

10.2 Нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж баталгаажуулснаар уг өөрчлөлт хүчин төглдөр үйлчилнэ.

10.3 Гэрээгээр хүлээсэн үргээ биелүүлэгэй, зохих ёсоор биелүүлэхээс татгалзсан тохиолдолд учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлнө.

10.4 Гэрээтэй холбогdon гарсан алтиваа маргааныг талууд харилцан тохиорлох байдлаар шийдвэрлэх ба эс зөвшөөрсөн тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

10.5 Талуудын үйл ажиллагаанаас ул хамаарах шалтганаар гэрээний үргийг биелүүлэх үед хяналтаас гаднах саад бэрхшээлээс болсон, гэрээ байгуулах үед тэр саад бэрхшээл, эсхүл түүний үр дагавараас зайлсхийх буюу даван туулах арга замыг урьдчилан тооцох боломжгүй /давагдашгүй хүчин зүйлийн нөлөө/ болсныг талууд нотолбол хариуцлагаас чөлөөлгөнө.

10.6 Гэрээний хавсралт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

**Судалгаа хөгжлийн төвийг
Бойжигч талыг төлөөлж:**

Төлөөлж: _____ " _____" ХХК-ийн
Инноваци, нэвтрүүлэлтийн
хэлтсийн дарга

Д.Даваадорж
/......./

Хаяг: 17042 Улаанбаатар хот

Хан-Уул дүүрэг 20 дугаар хороо
Чингисийн өргөн чөлөө өөрийн
байр

Утас: 976-70006011

И-Мэйл: incubator@rdc.gov.mn

Инкубаторт бойжигч компаниудад үзүүлэх үйлчилгээ

№	Үзүүлэх үйлчилгээний чиглэл	Үйлчилгээ	Хугацаа, тайлбар
1	Менторын чиглэлээр	-Хууль эрх зүй; -Татвар, санхүү;-Хүний нөөц;-Оюуны өмч; -Маркетинг, гаднын зах зээл дээр гаргах; -Борлуулалт, гадаад сайтад байршуулах талаар; Салбарын чиглэлээр сургалт, мэдээлэл, зөвлөх	Бойжигчдын үйл ажиллагааны чиглэлд хамааруулан холбогдох төрийн байгууллага, менежментийн багаар дамжуулан менторын дараах үйлчилгээг баталсан хуваарийн дагуу;
2	Оффисын чиглэлээр	-Ажлын байрыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын түрээсийн төлбөрийн доод хязгаараар; - Сургалтын өрөө; -Хурлын өрөө; -Уулзалтын өрөө;	Оффисын үйлчилгээг баталсан хуваарийн дагуу;
3	Маркетингийн чиглэлээр	-Судалгаа хөгжлийн төвийн вэб хуудас, олон нийтийн сүлжээгээр бойжигчийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах; - Судалгаа хөгжлийн төвийн хамтын оффис болон бусад төрийн байгууллагын уялдаа холбоог ашиглан бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үзэсгэлэн гаргахад туслах; -Дотоодын болон олон улсын гарцааны бизнесийг дэмжих сүлжээнд бойжигчийг үйл ажиллагааны чиглэлээс нь хамааруулах;	Шинэ бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ нэвтрүүлэх, үзэсгэлэн яармагт оролцсон үед бойжигчийн тавьсан саналыг үндэслэн;
4	Сургалтын чиглэлээр	-Арга хэмжээ, үзэсгэлэн, хурал, семинар, лекцүүдэд хамруулах;	Батлагдсан арга хэмжээний хуваарийн дагуу;
5	Бусад	ХХААХҮЯ болон Судалгаа хөгжлийн төвөөс зохион байгуулагдаж буй төлбөртэй болон төлбөргүй арга хэмжээнд оролцуулах;	Батлагдсан хуваарийн дагуу;